



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Халхгол нэгдэл” ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/021/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.1 Ерөнхий зүйл .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.2 Материаллаг байдал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..	<b>Error! Bookmark not defined.</b>
4.5.1 Завсрын аудитын талаар .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
Утас: 7058-4203

2026.03.13 № 350

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Г Хязгаарлалттай дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улзын хөгжил” ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Халаалтын орлогын гэрээ холбогдох анхан шатны баримтуудыг ирүүлээгүй тул сөрөг тулган баталгаажуулалт хийхэд 8,522.0 мянган төгрөгийн орлогыг зөрүүтэй тул 518,360.4 мянган төгрөг, түрээсийн 20,332.6 мянган төгрөгийн орлого олохтой холбоотой гэрээ, холбогдох анхан шатны баримтыг аудитад ирүүлээгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй 419,762.7 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн, байгууллагын дотоод журам тусгаагүй, шийдвэргүй 1,812.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг ажилчдад олгосон, санхүүгийн тайланд тусгагдаагүй НӨАТ-ын 15,484.2 мянган төгрөгийн өр, ААНОАТ-ын 5,089.5 мянган төгрөгийн өр, ХХОАТ-ын 1,907.0 мянган төгрөгийн авлага нийт 22,480.7 мянган төгрөгийг татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй нийт 982,748.4 зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, ашиг алдагдлыг төлөвлөн батлуулаагүй, санхүүгийн тайланг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн маягтаар бэлтгээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн байна.

~ 2126050178



Тус байгууллага нь зорилтот түвшний гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталдаггүй, тайлант хугацаанд ашигтай ажиллах зорилт тавьдаггүй, төсөвт байгууллагатай адилаар төсөв баталдаг, өөрийн үйл ажиллагааны орлогыг 1,073,570.2 мянган төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 674,674.2 мянган төгрөгийн орлого олж, орлогын төлөвлөгөө 62.8 хувьтай биелсэн байна.

#### **Аудитын гол асуудлууд**

Тус байгууллага нь нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч ба тайлант хугацаанд хийсэн борлуулалт, худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварын авлага, өрийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, 15,484.2 мянган төгрөгийн өр төлбөрийг татварын албатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн жилийн төлөвлөгөөг төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	18,440.43	1,319,542.02
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.6	Бараа материал	34,252,000.00	58,172,100.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	34,270,440.43	59,491,642.02
1.2.1	Үндсэн хөрөнгө	15,041,832,754.13	15,017,869,622.73
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	15,041,832,754.13	15,017,869,622.73
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,076,103,194.56</b>	<b>15,077,361,264.75</b>
2.1.1.2	Дансны өглөг	93,743,403.20	671,884.23
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	93,743,403.20	671,884.23
2.3	Өмч		
2.3.1	төрийн	-	-
2.3.2	хувийн		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	14,982,359,791.36	15,076,689,380.52
2.3.11	Эздийн өмчийн дүн	14,982,359,791.36	15,076,689,380.52
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,076,103,194.56</b>	<b>15,077,361,264.75</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,274,280,720.74	1,711,622,321.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого		-
9	Борлуулалт, маркетингийн зардал	703,486,666.27	302,221,405.59
10	Ерөнхий ба удирдлагын зардал	302,991,420.27	215,130,266.68
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	41,275,795.76	34,829,817.17
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	839,820,264.12	1,232,999,781.62
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-

16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,386,706,574.32</b>	<b>(73,558,950.06)</b>
19	Орлогын татварын зардал	-	-
<b>20</b>	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-	-
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>13,595,653,217.04</b>	<b>13,595,653,217.04</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
<b>3</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	1,386,706,574.32	1,386,706,574.32
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
<b>9</b>	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>14,982,359,791.36</b>	<b>14,982,359,791.36</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	167,888,539.22	167,888,539.22
<b>11</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	<b>15,150,248,330.58</b>	<b>15,150,248,330.58</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(73,558,950.06)	(73,558,950.06)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
<b>17</b>	<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	<b>15,076,689,380.52</b>	<b>15,076,689,380.52</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	936,051,755.04	674,674,210.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	936,051,755.04	674,674,210.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	940,032,864.35	673,373,108.41
1.2.1	Ажиллагчдад төлсөн	237,640,241.94	180,868,839.28
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	65,351,178.33	34,261,427.40
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	36,159,620.00	8,205,108.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	106,908,730.47	102,430,165.59
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	446,352,093.32	266,856,080.97
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	47,621,000.29	80,751,487.17
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,981,109.31)	1,301,101.59
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,999,549.74	18,440.43
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,440.43	1,319,542.02

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Татаас санхүүжилт	312,088,600.00	145,966,300.00	98,000,000.00	(47,966,300.00)	67.1
Үндсэн үйл ажиллагааны орлого	623,963,155.04	927,603,903.00	576,674,210.00	(350,929,693.00)	62.2
Бусад орлого	2,338,228,965.70	-	1,036,948,111.00	1,036,948,111.00	
<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,274,280,720.74</b>	<b>1,073,570,203.00</b>	<b>1,711,622,321.00</b>	<b>638,052,118.00</b>	<b>159.4</b>
Цалин хөлс	237,640,241.94	376,374,840.40	180,868,839.28	(195,506,001.12)	48.1
Байгууллага НДШ зардал	65,351,178.33	55,408,163.00	34,261,427.40	(21,146,735.60)	61.8
Ашиглалтын зардал	113,128,730.47	110,000,000.00	96,210,165.59	(13,789,834.41)	87.5
Хангамжийн бараа материалын зардал	590,357,935.80	436,587,200.00	206,011,240.00	(230,575,960.00)	47.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	41,275,795.76	95,199,999.60	34,829,817.17	(60,370,182.43)	36.6
Элэгдлийн зардал	839,820,264.12	-	1,232,999,781.62	1,232,999,781.62	
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,887,574,146.42</b>	<b>1,073,570,203.00</b>	<b>1,785,181,271.06</b>	<b>711,611,068.06</b>	<b>166.3</b>
<b>ТАТВАР</b>	-	-	-	-	
<b>ТАТВАРЫН ДАРААХ АШИГ</b>	<b>1,386,706,574.32</b>	<b>0.00</b>	<b>-73,558,950.06</b>	<b>-73,558,950.06</b>	<b>-</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 41,714.9 мянган төгрөгийн дараах 1 алдааг<sup>1</sup> аудитын явцад залруулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлэн бүртгэхдээ данснаас хассаны гарз 41,714.9 мянган төгрөгийг бүртгэсэн нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Толилуулга" зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж залруулав.

Мөн аудитаар нийт 983,668.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup>-д 982,748.4 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 920.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн санхүүгийн аудитын асуудлаарх зөрчил 563,905.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 553,170.0 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв

### 5.1 Албан шаардлага

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

1. Халаалтын орлогын гэрээ холбогдох анхан шатны баримтуудыг ирүүлээгүй тул сөрөг тулган баталгаажуулалт хийхэд 8,522.0 мянган төгрөгийн орлогыг зөрүүтэй тул 518,360.4 мянган төгрөгийг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "Анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
2. Тайлант онд түрээсийн 20.332.6 мянган төгрөгийн орлого олохтой холбоотой гэрээ, холбогдох анхан шатны баримтыг аудитад ирүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "Анхан шатны баримт гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй 419,762.7 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 44 дүгээр зүйлийн 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
4. Байгууллагын дотоод журам тусгаагүй, шийдвэргүй 1,812.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг ажилчдад олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.5.3-т "төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 20.2-т "Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.
5. Санхүүгийн тайланд тусгагдаагүй НӨАТ-ын 15,484.2 мянган төгрөгийн өр, ААНОАТ-ын 5,089.5 мянган төгрөгийн өр, ХХОАТ-ын 1,907.0 мянган төгрөгийн авлага нийт 22,480.7 мянган төгрөгийг татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Татварын ерөнхий хуулийн 30.2.8-д "тайланд тусгасан татварын тооцооны үлдэгдэл болон тухайн тайлангийн хугацаанд төлсөн татварын дүн татварын албаны бүртгэлтэй тохирч байгаа эсэхэд хяналт тавих", "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна", 14 дүгээр зүйлийн 14.1-д "Хувь хүн, хуулийн этгээдийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлснээс хойших хугацаанд энэ хуулийн 7, 8, 11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн доор дурдсан албан татварыг түүний төсөвт төлөх албан татвараас хасаж

тооцно”, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20.2.7-д “Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Цэвэр өмчийн хөрөнгөтэй холбоотой асуудал**

#### **1.1. Илрүүлэлт:**

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дэх цэвэр хөрөнгийн хэмжээ 920.0 мянган төгрөг, санхүүгийн тайлан дахь хөрөнгийн хэмжээ тэг төгрөг буюу 920.0 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 болон 13.1-д заасныг баримтлан, Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дэх оруулсан хөрөнгийн хэмжээг санхүүгийн тайланд тусгасан цэвэр хөрөнгийн хэмжээтэй тулган зөрүүтэй холбогдох хуулийн дагуу дүнг залруулах.

### **2. Санхүүгийн тайлангийн маягттай холбоотой асуудал**

#### **2.1. Илрүүлэлт:**

Санхүүгийн тайланг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн маягтаар бэлтгээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт "Санхүүгийн тайлангийн маягт" дагуу бэлтгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 дахь заалтыг баримтлан, санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1Үндсэн хөрөнгийг ангилал хооронд шилжүүлэн бүртгэхдээ данснаас хассаны гарз 41,714.9 мянган төгрөгийг бүртгэсэн	1	41,714.9			1	41,714.9	1	41,714.9				
Дүн	1	41,714.9			1	41,714.9	1	41,714.9	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Халаалтын орлогын гэрээ холбогдох анхан шатны баримтуудыг ирүүлээгүй тул сөрөг тулган баталгаажуулалт хийхэд 8,522.0 мянган төгрөгийн орлогыг зөрүүтэй тусгасан	1	518,360.4			1	518,360.4						
Тайлант онд түрээсийн 20.332.6 мянган төгрөгийн орлого олохтой холбоотой гэрээ, холбогдох анхан шатны баримтыг аудитад ирүүлээгүй	1	20.332.6			1	20.332.6						
Байгууллагын дотоод журам тусгаагүй, шийдвэргүй 1,812.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг ажилчдад олгосон	1	1,812.0			1	1,812.0						
Санхүүгийн тайланд тусгагдаагүй НӨАТ-ын 15,484.2 мянган төгрөгийн өр, ААНОАТ-ын 5,089.5 мянган төгрөгийн өр, ХХОАТ-ын 1,907.0 мянган төгрөгийн авлага нийт 22,480.7 мянган төгрөгийг татварын албатай тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	22,480.7			1	22,480.7						

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дэх цэвэр хөрөнгийн хэмжээ 920.0 мянган төгрөг, санхүүгийн тайлан дахь хөрөнгийн хэмжээ тэг төгрөг буюу 920.0 мянган төгрөгийн зөрүүтэй	1	920.0					1	920.0				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>563,905.7</b>	-	-	<b>4</b>	<b>562,985.7</b>	<b>1</b>	<b>920.0</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар												
Санхүүгийн тайланг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн маягтаар бэлтгээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн	1	-					1	-				
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй 419,762.7 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн	1	419,762.7			1	419,762.7						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>419,762.7</b>			<b>1</b>	<b>419,762.7</b>	--		-	-	-	-